



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2012 оны 01 сарын 19 өдөр

Дугаар 09

Мандалговь

Ашигт малтмал тээвэрлэх замын
маршрут батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын "л" дэх заалтыг үндэслэн Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Дундговь аймгийн нутаг дэвсгэр дээгүүр ашигт малтмал тээвэрлэх замын маршрутыг хавсралтаар баталсугай.

Хоёр. Ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжийн удирдлагад дараах зүйлсийг үүрэг болгосугай.

1. Батлагдсан замын маршрутын дагуу ашигт малтмал тээвэрлэх, маршрутын бус, шинэ зам үүсгэж тээвэрлэлт хийхгүй байх.

2. Говийн хөрсийг элэгдэлд оруулж хөрсний доройтол, хөрсний эвдрэл үүсгэхгүй байхад анхаарч маршрутын дагуух замыг сайжруулан засах, цаашид хатуу хучилттай авто зам тавих талаар ашигт малтмал тээвэрлэдэг аж ахуйн нэгж бүр санаачилгатай ажиллах.

3. Тос тосолгооны зүйл, төрөл бүрийн хог хаягдлыг хаяж хөрсний бохирдлыг үүсгэхгүй байх.

4. Улсын чанартай хатуу хучилттай зам ашиглан ашигт малтмал тээвэрлэхдээ нэг хөтлөгч дээрх хамгийн их ачааллыг 11 тн, хөтлөгдөх тэнхлэг дээрх хамгийн их ачааллыг 10 тн-оос хэтрүүлэхгүй байх стандартын шаардлагыг мөрдөх

Гурав. Батлагдсан замын маршрутыг аж ахуйн нэгж байгууллагад танилцуулан, орон нутагт байнгын хяналт тавьж ажиллахыг Сумдын Засаг дарга, цагдаа, байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарт үүрэг болгосугай.

Дөрөв. Маршрутын дагуух орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчилж хамгаалах, замын тэмдэглэгээ байрлуулах талаар төсөл, хөтөлбөр боловсруулж хэрэгжилтийг зохион байгуулах,

0150017

энэ талаар ААНБ-д үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулж ажиллахыг
Аймгийн Засаг /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

Тав. Батлагдсан замын маршрутыг мөрдүүлэх, маршрутын бус замаар ашигт
малтмал тээвэрлэсэн, даацын хэмжээг хэтрүүлсэн тохиолдолд холбогдох хууль,
дүрэм, журам, стандартын дагуу хариуцлага хүлээлгэж ажиллахыг аймгийн Авто
тээврийн төв /Ц.Бямбацогт/, Цагдаагийн газар /Б.Очирдорж/, Мэргэжлийн
хяналтын газар /Ш.Төрбат/, Байгаль орчин аялал жуучлалын газар /Н.Гантулга/
нарт үүрэг болгосугай.

ДАРГА



С.СҮХБААТАР